



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.03.09. № 02-01-001/36.

танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу танай байгууллагын харьяа Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрүүд, усан сан, насос станц, ус түгээх байр болон бохир ус цэвэрлэх байгууламжуудад төлөвлөгөөт шалгалт, хяналт шинжилгээ хийхдээ Усны тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Эрүүл ахуйн тухай хууль болон тэдгээр нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих тул үйл ажиллагаандаа дараах зөвлөмжийг анхаарч ажиллана уу. Үүнд:

Нэг. Усны чанар, аюулгүй байдлыг хангах талаар:

- 1.1. Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу хүн амын хэрэглэж байгаа ундны болон ахуйн усны чанар, аюулгүй байдалд холбогдох стандартын дагуу хяналт шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээ авах;
- 1.2. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу Улаанбаатар хотын хүн амын ундны усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоох;
- 1.3. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-д заасан дэглэмийг зөрчихгүй байх;
- 1.4. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д заасны дагуу онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахгүй байх;
- 1.5. "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын 3.10-д заасны дагуу ус хангамжийн эх

001150501138

үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд гадны хүн орох, автотээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах, мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих, ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах, бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх, газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгохыг хориглох;

1.6. "Хот суурины ундны ус түгээх цэгийн үйлчилгээ Ерөнхий шаардлага" MNS 5775:2014 стандартад заасны дагуу ундны ус түгээх цэгийг бие засах газар, бохир усны цооногоос 20 метрээс дээш зайд байрлуулан хашаа хайс хийж, орчныг тохижуулах, ус нөөцлөх савыг улирал бүр халдваргүйжүүлэн, үлдэгдэл бодисын хэмжээг лабораториор хянан баталгаажуулах;

1.7. Эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.8-д заасны дагуу ажилтнаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах;

Хоёр. Бохир усыг цэвэрлэн зайлуулах талаар:

2.1. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх;

2.2. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д заасны дагуу хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, технологийн дагуу цэвэрлэх, чанар, аюулгүй байдлын шаардлагад хяналт тавих;

2.3. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу технологийн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэхдээ байгаль орчин, эрүүл мэнд, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагуудын хамтран тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтлах;

Гурав. Дээрхи зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллаагүй тохиолдолд дараах хуулийн дагуу хариуцлага хүлээхийг анхаарна уу. Үүнд:

3.1. Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д заасныг зөрчсөн албан тушаалтныг Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөс хоёр сая төгрөгөөр хяналтын байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч торгох;

3.2. Усны тухай хуулийн 22.2 1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөчөөс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх.

3.3. Усны тухай хуулийн 22.6, 22.15-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас дөч дахин, аж ахуйн нэгж, байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

3.4. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14.2.3-т заасныг зөрчсөн бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, буруутай иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

Иймд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын ub.inspection.gov.mn сайтаас “Ундны усны чанар, аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг татан авч, дотоодын хяналтдаа ашиглаж, холбогдох хууль тогтоомж, журам, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг зөвлөж байна.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л.ЭРДЭНЭЧУЛУУН